

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

2024 оны X сар

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ
ЗГ-ын тогтоол						
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан</p>	<p>УБЕГазрын хүний нөөц, сургалтын системд байршуулсан бие даан судлах хичээлийн монгол бичгийн цахим хичээлийг албан хаагчид тогтмол судалж байна. Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгож уг булангаар дамжуулан "Уламжлал" сэтгүүлтэй танилцах, төрийн албан хаагчдын уралдаанд оролцсон бичвэр материалууд болон сонин сэтгүүл, толь бичгээс мэдээлэл авах харах боломжоор ханган эх хэл уйгаржин монгол бичгийн талаар иргэдэд сурталчилж ажиллаж байна. Хэлтсийн гадна хаяг болон дотор тасалгаануудын хаягийг крилл болон монгол бичгээр бичин байрлуулсан. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд улсын бүртгэгч нар иргэний улсын бүртгэлийн онлайн програмын нэрийн санд монгол бичгээр бичиж төрсний гэрчилгээ, гэрлэлт бүртгэлийн гэрчилгээг крилл болон монгол бичгээр бичигдсэн байдлаар хэвлэж олгодог. Байгууллагын өрөө тасалгааны хаяг, 5</p>	100%	100%

			<p>дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>	<p>албан хаагчийн нэрийн хуудсыг крилл, монгол бичгээр хослуулан хийсэн. Албан хэрэгцээний баримт бичгийн хаягийг монгол бичгээр хослуулан бичиж хэвшсэн. 2024.04.01-ний өдрөөс албан хэрэг хөтлөлт хос бичгээр үйлдэн туршилтын журмаар хэрэгжүүлж байна.</p>		
2	2	<p>2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49</p>	<p>X-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;</p>	<p>Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн пэйж, Веб хуудсанд авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулж, шүгэл үлээхийг сурталчлан таниулах болон авлигын мэдээллийг оруулан сурталчиллаа.</p>	100%	100%
	3		<p>X-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.</p>	<p>Улсын бүртгэлийн хэлтсээс 8 суманд 10 удаагийн “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээгээр 1950 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэж, 624 улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Мөн тус хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс 2024 оны 03 сарын 04-нөөс 05 сарын 31-ний хооронд төрийн үйлчилгээний сэтгэл ханамж, төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйн талаар QR код уншуулан илгээлгэж судалгаа авсан. Уг судалгаанд 100</p>	100%	100%

				гаруй иргэн хамрагдаж саналаа өгсөн . Санал өгсөн иргэдийн 85% албан хаагчдын үйлчилгээнд талархсан, 15% нь цаашдын ажил үйлчилгээнд анхаарч сайжруулж ажиллах талаар санал өгсөн байна. Энэ судалгааны үр дүнд албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч “Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй”-н сургалтанд хамрууллаа		
3	4	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)	Улсын бүртгэлийн байгууллага нь Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам, Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах түүний аюулгүй байдлыг хангах журам, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хаалттай мэдээлэлтэй танилцах, мэдээлэл өгөх журмыг үйл ажиллагаа мөрдөн ажилладаг бөгөөд УБЕГ-ын Мэдээлэл технологийн газар хяналт тавьж ажилладаг.	100%	100%
4	5	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг	Тус хэлтэс нь 2024 оны 4-р сараас ЗГ-ын 82-р тогтоолоор батлагдсан төсөвт багтаан орон нутагт ажилласны нэмэгдэл сар бүр улсын төсвөөс болон	100%	100%

		<p>тухай 2024-02-28 Дугаар 2024_82</p>	<p>батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)</p>	<p>орон нутгийн төсвөс олгож байгаа болно.</p>		
5	6	<p>Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83</p>	<p>3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.)</p>	<p>Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын дүнг үндэслэн төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулалыг төсөвт багтаан олгон ажиллаж байна. Төрийн захиргааны албан хаагчдад нэг удаагийн урамшуулал 27 албан хаагчдад 164,822,500 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосноос ХХОАТ 16,482,250 төгрөгийг суутгасан болно. 2025 оны төсвийн төсөлд санхүүжилтийг тусган ажиллаж байна.</p>	100%	100%

6	7	<p>Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196</p>	<p>3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай</p>	<p>Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын цалин, хөдөлгөөн, бусад мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байгаа бөгөөд шинээр томилогдсон албан хаагчдын мэдээллийг нэмж, томилогдсон болон чөлөөлөгдсөн тушаал шийдвэрийг сканердан оруулж байна. Түүнчлэн хүний нөөцийн тайланг УБЕГ-аар дамжуулан Төрийн албаны салбар зөвлөлд тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Хэлтсийн даргын 2024 оны 01-р сарын 02-ны өдрийн 01 дүгээр “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, улсын бүртгэлийн үйлчилгээний стандартыг сайжруулах, үйл ажиллагаандаа мөрдөх, талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тушаалаар нийт албан хаагчдад 12 заалтаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100%	100%
7	8	<p>Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215</p>	<p>4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Оосх)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн</p>	<p>Төв аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ болон бусад байгууллагаруу албан бичиг илгээх хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Edoc)-ийг ашиглаж байгаа бөгөөд хувийн email хаяг, олон нийтийн нийгмийн сүлжээгээр албан бичгийг дамжуулан, хүлээн авахгүй байгаа болно.</p>	100%	100%

			байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл						
8	9	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	ХИҮ.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны үйлчилгээний чанар хүртээмж, авлига хүнд суртлыг байгаа эсэхэд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх зорилгоор “Энэрэнгүй Үйлс” НҮТББайгууллагатай гэрээ байгуулж хэрэглэгчийн хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлж тайланг Улсын бүртгэлийн Ерөнхий газарт хүргүүлсэн.	100%	100%
9	10	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	ХИХ.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус	Тус хэлтсийн 2024 хүний эрхийн төлөвлөгөөг 5 зүйл заалттайгаар хэлтсийн даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	100%

			үүрэг болгов			
10	11	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	Тус хэлтэс нь 2024 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ байхгүй болно.	100%	100%